

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Нээлттэй Нийгэм Форум нь Монголын Хуульчдын Холбооны Эрүүгийн эрх зүйн хороотой хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвт 8 цуврал хэлэлцүүлгийг мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, их дээд сургуулийн багш нар, хохирогч хамгааллын чиглэлээр ажилладаг ТББ-ын ажилтан зэрэг нийт 150 орчим мэргэжилтнийг оролцуулан 2018 оны 4-р сарын 20-ны өдрөөс 5-р сарын 22-ны хооронд зохион байгуулсан билээ. Хэлэлцүүлгийн үеэр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг авч хэлэлцлээ.

Эхний 6 цуврал хэлэлцүүлгийг тодорхой ажил мэргэжлийн хүрээнд хийсэн бол сүүлийн хоёр хэлэлцүүлгийг бүх талын төлөөллийг оролцуулан зохион байгуулснаараа онцлогтой. Үүний дүнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг аль болох олон талын оролцоог ханган тодорхойллоо. Хуульчид, хууль сахиулагчдын өмнө тулгарч буй асуудал нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдлийг эрэлхийлэхэд оршиж буй тул гарсан бүхий л санал шүүмжийг нэг бүрчлэн тусгахыг эрмэлзсэн болно. Үүний зэрэгцээ бүх асуудалд бус зарим нэгд зарчмын зөрүүтэй байр суурь, эсхүл тодорхой санал гарсныг тусгасны улмаас бичиглэл, найруулгын хувьд нэг мөр болоогүйд хүлцэл өчье.

Хэлэлцүүлгээс гарсан тулгамдсан асуудлыг нийтлэг болон тусгай асуудлууд хэмээн хоёр бүлгээр танилцуулж байгаа бөгөөд дээрх 4 хуулийн хүрээнд нийтлэг 90, тусгай 266 тулгамдсан асуудлыг тодорхойлоод байна. Энэхүү хуулийн шүүмж нь эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хэрэгжүүлэх албан тушаалтныг чадавхжуулах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх дүрэм журам, удирдамж, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулахад хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

Хэлэлцүүлэгт оролцсон хуульчид, хууль сахиулагчид, иргэний нийгмийн ажилтнуудын нэрсийг хавсаргасан болно.

Нэг. Нийтлэг асуудал

- 1.1. Эрх зүйн ямар онолд тулгуурласан нь тодорхойгүйн улмаас тайлбарлаж хэрэглэхэд зөрчилдөөн болон ойлголтын зөрүү үүсч байна.
- 1.2. Ерөнхий анги нь тусгай ангитайгаа зөрчилдөх тохиолдол олон гарч байна.
- 1.3. Хууль хэрэгжээд нэг жил орчим хугацаа өнгөрч байгаа ч хуулийг нэг мөр ойлгож хэрэглэж хэвшээгүй байна. Үүний нэг нь эрүүгийн хуулийн тусгай ангид зарим тодорхой төрлийн гэмт хэргийг тодорхойлох хэд хэдэн, олон шинжийг тусгахдаа хууль зүйн техник буюу таслал, цэгтэй таслалыг янз бүрээр хэрэглэсэн явдал юм. Иймд зарим тодорхой төрлийн гэмт хэргийн хэд хэдэн болон олон шинжийг хэрхэн зөв ойлгох талаар хуулийг боловсруулсан эрдэмтэн судлаачдын саналыг үндэслэн хэл зүйн шинжилгээ хийлгэж, таслал, цэгтэй таслалыг оновчтой хэрэглэх шаардлагатай байна. Тухайлбал, 23.2-р зүйлд хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэргийг тодорхойлох олон шинжийг хуульчлахдаа зөвхөн таслал хэрэглэсэн бөгөөд эдгээр олон шинжийн чухам аль нь бүрдсэнээр гэмт хэргийн шинж бүрэлдэх нь тодорхой бус байна.
- 1.4. Эрүүгийн хуулиас “ял шийтгэгдсэн” болон “ялтай байдал” гэх ойлголтыг хассанаас гэмт хэрэгт холбогдож, шүүхээс ял шийтгэгдсэн албан тушаалтан нийтийн албанд эргэн томилогдох нөхцөл үүсээд байна. Тухайлбал хулгай дээрэм хийх, албан тушаалын байдлаа урвуулах, залилах гэмт хэрэгт холбогдсон этгээд шүүхээр ял шийтгэгдсэний маргааш нийтийн албанд томилогдох, ажлаа үргэлжлүүлэн хийх нөхцөл бүрдсэн байна. Төрийн албаны тухай хуульд төрийн албан тушаалтан томилогдоход тавигдах шаардлагад ял шийтгэгдсэн бол төрийн албанд томилохгүй байхаар заасан. Гэтэл Эрүүгийн хуульд ял шийтгэгдсэн, ялтай байдал гэх ойлголт байхгүйгээс дээрх хуулиуд хоорондоо зөрчилдөж, гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд төрийн болон нийтийн албан тушаалд томилогдох боломжтой болж байна.
- 1.5. Ялтай байдал гэдэг ойлголтыг хассан хэдий ч мөрдөгч ял шалгах хуудсыг хэргийн материалд заавал оруулж байгаа нь ял оногдуулахад нөлөөлж байна.
- 1.6. Ялын бодлого хуулийн үндсэн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэхийг нягтлах шаардлагатай. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэргийг шүүхэд шилжүүлэхэд, эргэлзээтэй байвал шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг баримтлан ял оногдуулахгүй байх зэрэг хуулийн хийдэл их байна.
- 1.7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн заалтуудыг мөрдөгч, прокурор, шүүгч практикт бүрэн гүйцэд хэрэглэхгүй байна. Тухайлбал, эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг практикт хэрэглэхгүй байна (4.1, 4.2, 4.3 аргагүй хамгаалалт гарцаагүй байдал).
- 1.8. Зөвлөмж гаргах замаар хуулийг буруу хэрэглэж байна.
- 1.9. Хуульд хувь хүний нууцыг авч үзсэн ч хуулийн этгээдийн нууцыг хэрхэх нь тодорхойгүй.
- 1.10. Хулгайг гэмт хэрэгт тооцох, насанд хүрээгүй хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.
- 1.11. Хуулийн зохицуулалт тодорхой байхад хэрэглэдэггүй, зөрчдөг байдал их байна. Үүнд хуульчид, хууль сахиулагчдын хандлага их нөлөөлж байна. Тиймээс хуульчдад зориулсан сургалтыг хэрэглээ тал дээр анхаарсан, чанартай, үр өгөөжтэй зохион байгуулахад анхаарах шаардлагатай.
- 1.12. Гэмт хэрэг үйлдэх санаатай, болгоомжгүй хэлбэрийг дахин нягтлахгүй бол болгоомжгүй үйлдсэн үйлдэл гэмт хэрэгт тооцогдож байна. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэргийн субъектив талын шинж буюу санаатай

эсвэл болгоомжгүй аль нь болохыг тодорхой заагаагүйгээс энэ заалтын хамаарах хүрээ өргөжиж, хилсээр ял шийтгэх нөхцөл үүссэн. 2002 оны эрүүгийн хуульд санаатайгаар хөнгөн гэмтэл учруулсан бол гэмт хэрэг гэж тооцдог байсан.

Эсрэг санал: Болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдоно. Тиймээс ойлгомжтой гэж үзэж байна.

- 1.13. Хуучин хуулийн 57.3 дахь зохицуулалт шинэ хуулиар байхгүй болсон байна. Үүний улмаас шүүх дээр хэрэг нэгтгэж болохгүй, ял нэмж болохгүй, дараа дараагийн ажиллагаанд хүндрэл учирч байна. Ял нэмж болохгүй болохоор шүүх буцаахаас өөр аргагүйд хүрч нилээн хэдэн хэрэг буцаад байна.
- 1.14. Хуулийн тусгай ангид байгаа “ноцтой хохирол”, “их хэмжээний хохирол” гэх мэт олон янзын тодорхойлолтыг 2.5 дугаар зүйлийн 4-тэй нийцүүлэх шаардлагатай.
- 1.15. Сэтгэл санаа хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр хохирол учруулах гэмт хэргийг шинээр хуульчлах шаардлагатай байна.
- 1.16. Нээлтэй, хаалттай хорих байгууллага гэдэг ойлголтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.
- 1.17. Шүүх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа ял эдлүүлэхэд саад болохуйц өвчнөөр өвчилсөн тохиолдолд ялсныг ял эдлэхээс чөлөөлж болох бөгөөд энэ журмыг хуулиар тогтоосон эсэх нь ойлгомжгүй.
- 1.18. Эрүүгийн хуулиар хүн худалдаалах гэмт хэргийн төрлийг хэт задалж хуульчилсан нь хуулийн хэрэглээг ойлгомжгүй болгосон. Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах, албадан хөдөлмөрлүүлэх, хүүхэд худалдах, хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхдэд садар самууныг сурталчлах, хүүхдийг оролцуулж садар самууныг сурталчлах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх г.м.
- 1.19. ХЭҮК, Монголын эмэгтэйчүүдийн сангийн мэдээгээр “Монгол Улсад 3 хүн тутмын 1 нь ажлын байрны бэлгийн дарамтын хохирогч болж байна” гэсэн судалгааг 2017 онд гаргасан. 2015 онд шинэчилсэн Эрүүгийн хуулийн 12.4 дүгээр зүйлд “Бэлгийн дарамт учруулах”-ыг гэмт хэрэгт тооцсон байсныг 2017 оны нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүйд тооцсон нь ухралт болсон. Тиймээс “бэлгийн дарамт”-ыг хуульд дахин гэмт хэрэг болгон тусгах шаардлагатай байна.
- 1.20. Эрүүгийн хууль нь системчлэл, дэс дараалал муутай байна. Тухайлбал, ердийн бүрэлдэхүүн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний уялдаа холбоо алдагдсан. Тухайлбал, үндсэн бүрэлдэхүүний шинжгүй байхад хүндрүүлж зүйлчлэх нь буруу юм. 17.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн хангагдаагүй байж, хүндрүүлэх бүрэлдэхүүнийг оруулж ирсэн.
- 1.21. Зорчих эрхийг хязгаарлахтай холбоотойгоор цахим бугуйвч зэрэг шаардлагатай технологийг нэвтрүүлэхэд нийт 17 тэрбум төгрөг шаардагдана гэсэн тооцоо байна. Энэ хэр үндэслэлтэй тооцоо болох, тэрчлэн монголын нөхцөл байдлыг харгалзсан эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал, зорчих эрхийг хязгаарлах ялыг малчинд оногдуулах эсэхийг бодолцоогүй. Энэ нь цаашлаад малчин хүний аж амьдралаа залгуулах эрхийг нь зөрчиж, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх боломжийг нь хязгаарлаж байна. Өмнөх хуулиараа амжилттай хэрэгжиж байсан сайн туршлагыг хадгалж үлдэх хэрэгтэй. Тухайлбал, байгууллагатай нь хамтран цалингийн тодорхой хэмжээг хасах ялын төрлийг сэргээх гэх мэт. Түүнчлэн суурин болон нүүдэлчин соёлд аль алинд нь тохирох, хүний эрхийг дээрдүүлэх, төрийн албанд хэт ачаалал үүсгэхгүй байх талаас нь ялын бодлогыг тодорхойлох шаардлагатай. Ингэхдээ аль болох техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, ашиглах тал дээр анхаарах нь зүйтэй.

- 1.22. Эрүүгийн хуулийн тусгай ангид тусгагдсан “шунахай” гэдэг тодорхойлолт нь эрүүгийн процесст тодорхойгүй байдал үүсгэж байна.

Санал: Иймд нэг мөр хуулийн тодорхойлолтыг эцэслэх, эсхүл хуулиас хасах. Субъектив байдлыг үнэлэх боломжгүй гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг дагаад хуулиас энэ үгийг хасах саналтай

Хоёр. Тусгай асуудал

- 2.1 Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1.10 дугаар зүйлийн 1, 2 дах хэсэгт ялгамжтай тогтоосон нь тодорхойгүй байдлыг бий болгож байна.
- 2.2 Хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 “хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн”, 1.2 “хорих ялын доод хэмжээг 1 жил, дээд хэмжээг 8 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн” хугацаанд хянан хэлэлцэхээр заасан. Хооронд нь завсрын хугацаа гарч, тухайн хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна. Тухайлбал, 11.7 дугаар зүйлийн 2 дах заалтад заасан гэмт хэрэгт 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан. Энэ гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны алийг авах нь эргэлзээтэй байна. Төстэй заалтуудаас дурьдвал, 17.1.1, 17.2.1, 17.3.1, 22.10.1 г.м. Мөн хуулийн 18.7.4-т зөвхөн торгох ялтай тул хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна.
- 2.3 Хуулийн хөөн хэлэлцэх хугацаа зарим төрлийн гэмт хэрэгт ял завших боломжийг олгож байна. Тухайлбал, “татвар төлөхөөс зайлсхийх” гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 1 жил байгаа нь гэм буруутай этгээдэд ял завших боломжийг олгосон. Татварын тайлан, аудит, хяналт гээд процессын хугацаа урт байдаг. Мөн авлига, албан тушаалын гэмт хэрэг илрэх хугацаа, үйлчлэл нь эрх мэдлийн хүрээнд илрэх магадлал бага атал хөөн хэлэлцэх хугацаа богино байгаа нь ял завших боломж олгож байна.

Санал: Эрүүгийн хуулийн 1.10-ийн 4 дэх хэсэгт авлига, албан тушаалын гэмт хэргийг нэмж тусгах, үгүй бол эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хөөн хэлэлцэх хугацааг тооцох, үгүй бол 1.10.2-ыг хасах.

- 2.4. Хуулийн 1.3 дугаар зүйлд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт нь ЭХХШТХ-ийн 20.1 дүгээр зүйлийн 2 дах заалттай зөрчилдөж байна. Нэг гишүүнтэй хуулийн этгээдийг яах ёстой тал дээр эргэлзээ үүсдэг. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх заалтад “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан бөгөөд ЭХХШТХ-ийн 20.1 дүгээр зүйлийн 2 дах заалтад “Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсвэл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана”, 20.1 дүгээр зүйлийн 3 дах заалтад “Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн гэмт хэрэгт хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж байгаагаас үл хамаарч явуулж болно” гэж заасан. Хуулийн дээрх заалтаас үүдээд тухайн гэмт хэрэгт холбогдсон хуулийн этгээд нэг гишүүнтэй бөгөөд хуулийн этгээдийг төлөөлөх өөр этгээд байхгүй бол “хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч”-өөр болон “хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө

үйлдэл хийсэн хүн”-ээр тус тус давхар эрүүгийн хэрэг үүсгэж, ялагдагчаар татахаар харагдаж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дах заалтад заасан “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн зарчимтай зөрчилдөж байна.

- 2.5. Хуулийн 1.8 дугаар зүйлийн 2 дах заалт нь гэмт хэрэг төгсөөгүй бол гэмт хэрэг үйлдсэн хугацааг тоолох боломжгүй болгосон. Иймд гэмт хэрэг төгссөн үеэс хугацааг тоолох бус гэмт хэрэг үйлдсэн үеэс тоолох нь зүйтэй.
- 2.6. Хуулийн 2.2 дугаар зүйлийн 3 дах заалтад заасан “үргэлжилсэн үйлдэл”-ийг тодруулах шаардлагатай. Энэ нь “нэгдмэл гэмт хэрэг”-ээс ялгаатай эсэх нь тодорхойгүй. Тухайлбал, объект өөр байвал хэрхэн шийдэх вэ гэсэн асуудал тулгарч байна. Агуулахын нярав өдөр бүр масло илүү гарган аваад байгааг үргэлжилсэн үйлдэл гэж үзэх үү, эсхүл нэг айлаас хулгай хийж гараад өөр айлаас хулгай хийхийг “үргэлжилсэн үйлдэл” гэж үзэх үү гэдэг нь тодорхойгүй байна. Үргэлжилсэн үйлдэлтэй гэмт хэргийг тодорхойлохдоо онолын ойлголт буюу “нэг объектод удаа дараа халдсан үйлдэл” болохыг тусгаагүйгээс хэд хэдэн гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах боломжийг олгосон.
- 2.7. Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дах хэсэгт заасан “ноцтой хохирол” гэсэн тодорхойлолтын тайлбар ойлгомжтой боловч тусгай ангид зарим гэмт хэрэгт “ноцтой хор уршиг” гэсэн нь тодорхойгүй байдал үүсгэж байна. “Ноцтой хор уршиг”-ийг хэрхэн тодорхойлох талаар ойлголт байхгүй байна.

Санал: Иймд хуулийн тодорхойлолтыг нэг мөр эцэслэх, эсхүл хуулиас хасах.

- 2.8. Хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх заалтад хохирлын хэмжээг ойлгомжгүй томъёолсон. Тухайлбал, 300 нэгжээс 10000 нэгжийн хоорондох хэмжээг тодорхойлоогүй.
- 2.9. Хууль хэрэглэхэд хүндрэл учруулж байгаа тул Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийг хасах нь зүйтэй.
- 2.10. Хуулийн 4.1, 4.2, 4.3 дугаар зүйлд заасан нэр томъёог шууд утгаар, тодорхой илэрхийлэх шаардлагатай.
- 2.11. Хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “бусад” гэж нэмж оруулах шаардлагатай. Эрх зүйн байдлыг дордуулсан заалт учир хуучин тайлбар, ойлголтоор тайлбарлах нь зүйтэй. Тухайлбал, “Аргагүй хамгаалалтын байдалд, энэ хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй” гэх байдлаар тайлбарлаж болох юм. Мөн аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлэх тухай ойлголт байхгүй болсон. Довтолгооны эсрэг хийж байгаа үйлдэл нь аргагүй хамгаалалт болдог. Гарцаагүй байдал бол гамшигт болон хүний үйл ажиллагаатай холбоотой үйлдэл байж болдог. Аюултай халдлагаас өөрийн ойр дотнын болон бусад хүмүүсийг хамгаалах боломжтой. Аргагүй хамгаалалт хийхийн тулд ойр дотнын гэдгийг нэмж дэлгэрүүлэхгүй бол хүмүүс бусдад туслахгүй байх нөхцөлийг үүсгэж байна. Тухайлбал, 4.1 дүгээр зүйлийн тайлбарт “найз охин” гэх зэрэг хүмүүс хамаарахгүй байдлаар тайлбарласан. Үүнээс үүдэж тус тайлбарт багтаагүй ойр дотнын хүнийг хамгаалснаараа гэмт хэрэгт холбогдох, эсхүл хамгаалалгүй орхиод явах нөхцөлийг бүрдүүлжээ. Иймээс тус ойлголтыг өөрийн, бусдын гэх байдлаар дэлгэрүүлэх нь зүйтэй.
- 2.12. Хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дах заалтад ял оногдуулна гэсэн нь албадагын арга хэмжээг орхигдуулсан байна.
- 2.13. Хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.3 дах заалтад зорчих эрхийг хязгаарлах ялыг хэт хавтгайруулан тусгай ангид заасныг эргэж харж, оногдуулах боломжтой гэмт хэрэгт оногдуулахаар өөрчлөх шаардлагатай. Тухайлбал, мал хулгайлах, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахаар зохицуулсан.

- 2.14. Хуулийн 5.4-р зүйлийн 1 дэх заалтад “Шүүхээс тогтоосон” гэснийг тодруулж тайлбарлах шаардлагатай. Шүүхээс ямар төрлийн ажил хийхийг заах шаардлагатай эсэх, тухайлбал, шүүгдэгчийг ямар байгууллагад хөдөлмөр эрхлүүлэх талаар санал авч, тогтоол гаргах явцад нөгөө байгууллагын ажил дууссан байх тохиолдол гарч байна.

Санал: Шүүхийн шийдвэрт хохирол, хэмжээ, ажил зэргийг заавал заах шаардлагагүй.

- 2.15. Хуулийн 5.4 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “...нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно” гэж заасан нь ялын зорилгод тохирохгүй байна. Энэ ялын зорилго нь нийтэд тустай ажил хийлгэх учраас хугацаагаар ялын зорилгыг тайлбарлаж болохгүй. Тиймээс уг заалтын “дөрвөөс дээшгүй цагаар” гэснийг “наймаас дээшгүй цагаар” гэж өөрчлөх. Практикт, ихэвчлэн ажилгүй хүмүүст нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэл оноож байна. Ер нь хувийн байдлыг харгалзан ялыг оноох гэсэн заалт нэмж оруулах нь зөв. Энэ заалтад “цаг”-ийг заавал тусгах ёстой эсэхийг тодруулах шаардлагатай. Зарим тохиолдолд, албадан хөдөлмөр эрхлүүлэхээр хэрэгтнийг явуулахад аж ахуйн нэгжийн дарга гэрийн үйлчлэгч хийлгэж, тухайн этгээд гэрээс нь хулгай хийсэн тохиолдол гарсан.
- 2.16. Хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4, 5.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар солих үндэслэлийг хуульчилсан. Гэвч тусгай ангид тухайн гэмт хэрэгт хорих ял шийтгэхээр заагаагүй байхад уг ялыг биелүүлээгүй гэж шүүгчийн захирамжаар хорих ялаар солих нь “шударга ёсны болон хууль ёсны” зарчимд нийцэх эсэх нь эргэлзээтэй. Учир нь хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ял оногдуулах”, 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “нэг гэмт хэрэгт нэг л удаа ял оногдуулах”-аар заасан. Тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хэд, хэдэн төрлийн ялаас сонгон хэрэглэх боломжтой атал ялыг зөв сонгоогүй буюу биелүүлэх боломжгүй ял оногдуулсан нь тухайн ял шийтгүүлж байгаа этгээдийн сонголт, алдаа биш юм. Нөгөө талаас шүүхийн шийтгэх тогтоол заавал биелэгдэх учиртай.
- 2.17. Ерөнхий анги, тусгай анги хоорондоо зөрчилдөж байна. Тухайлбал, хуулийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх заалтад “... нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглохыг эрх хасах ял гэнэ.”, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “...гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж...” гэсэн нь, 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “...хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.”, 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг “гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” зэрэг ялгамжтай тодорхойлжээ.
- 2.18. Ялыг нэгтгэж тогтооход баримтлах хуулийн заалт тодорхой бус байгаагаас шүүхээс өөр өөрөөр шийдэж байна.

Санал: Нэгтгэн ял эдлүүлэх заалтад өөрчлөлт оруулах

- 2.19. Хуулийн 6.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг хоорондоо зөрчилдөж байна.

Санал: 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “хүнд” гэдгийг хасах саналтай.

- 2.20. Хуулийн 6.7 дугаар зүйлд зөвхөн “хорих ял” оногдуулах хэрэгт хамаарахаар байгаа нь “ялаас чөлөөлөх” гэснийг хэрэглэхэд эргэлзээ үүсгэж байна. Мөн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх заалтад зааснаар “зорчих эрхийг хязгаарлах ял”-аас 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-ыг үндэслэн ялаас чөлөөлж болохоор заажээ. Мөн энэ нь 7.1 дүгээр зүйлээс ялгаатай эсэх нь тодорхойгүй. Нөгөө талаас нийтэд тустай ажил хийлгэх, торгох ялаас чөлөөлөх

талаар зохицуулалт байхгүй байгаа нь үйлдсэн гэмт хэргээр нь ялгаварлаж, шударга ёсны зарчмыг зөрчсөн гэж үзэхээр байна. Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн бол хорих ялаас чөлөөлж байгаа нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцэх эсэх нь эргэлзээтэй. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүн гэдгийг хэрхэн тайлбарлаж хэрэглэх нь тодорхойгүй. Шүүхээс өмнөх, эсхүл шүүхийн шатанд, анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд гэм буруугаа хүлээн зөвшөөрснийг ойлгох эсэх нь эргэлзээтэй.

Санал: Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд тусгагдсан “хорих” гэх ойлголтыг хассанаар бусад ялд дээрх зүйлийг хэрэглэх боломж бүрдэнэ.

- 2.21. Эрүүгийн хуульд заасан тэнсэх ойлголтыг нэг мөр болгох зорилгоор хуульд тусгагдсан 6.7-р зүйлийн 1.1 дэх хэсэг хэсэгт заасан “..гурван жил хүртэл хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх...” , 1.2 дахь хэсэгт заасан “...таван жил, түүнээс бага хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх...” гэх хэсгийг хасаж, хуулийн 7.1 дүгээр зүйлд тэнсэх зохицуулалтад тус ойлголтыг нэг мөр тусгаж, тодорхой болгох шаардлагатай.
- 2.22. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх явдал гарч байна. Тухайлбал, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг болон хэд хэдэн шийтгэх тогтоол оногдуулахаар 6.8, 6.9 дээр тодорхой заасан боловч шүүхээс эрх зүйн байдал дордоно гэсэн үндэслэлээр хэрэгжүүлэхгүй байна.
- 2.23. Хуулийн 6.9 дүгээр зүйлийн 1-д “шинэ” гэж орсны улмаас ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдвол эдлэх ялын хэмжээг хэрхэн тогтоох нь орхигдсон.
- 2.24. 2002 оны ЭХ-ийн 58, 2015 оны ЭХ-ийн 6.9-ийг аль тохиолдолд хэрэглэх нь тодорхойгүй байгаагаас хольж хэрэглэж байна. Зарим хүний хувьд хэрэг нь хөнгөрөөд, зарим хүний хувьд хүндрээд байна.
- 2.25. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.15-р зүйлд гэмт хэрэг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд хуулийн хөнгөлөлт үзүүлэх шинэ заалт орсон ч үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болон хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд хамаарахаар заалт болжээ. Бусад төрлийн гэмт хэрэг буюу хөнгөн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас хэсэгчлэн чөлөөлөх тухай заалтыг нэмж оруулах шаардлагатай. Энэ нь гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, хохирогчийн эрхийг хамгаалахад ахиц гаргана.
- 2.26. Хуулийн 7.1 дүгээр зүйлд орсон “тэнсэх” нь эрүү шүүлт тулгахаар заалт болсон. Гэм буруугаа хүлээвэл тэнсэнэ, хүлээхгүй бол хорино гэсэн байдлаар хандаж байна.
- 2.27. Хуулийн 7.3 дугаар зүйл хохирлоо төлсөн, согтуугаар автомашин жолоодоогүй гэх мэт нөхцөлд үүрэг хүлээлгэх, эрхийг нь хязгаарлах албадлагын арга хэмжээнээс тохируулж хэрэглэх нөхцөл нь учир дутагдалтай.
- 2.28. ЭХ-ийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь заалт, ЭХХШТХ-ийн 16.4 дүгээр зүйлд заасан “техник хэрэгсэл”-ийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй. Мөн 16.4-т “хэрэглэсэн бол” гэж, 7.5 дугаар зүйлийн 2-д “ашигласан бол” гэж ялгаатай үг хэрэглэсэн нь эргэлзээ үүсгэж байна. Шүүхээр орсон 2, 3 хэрэгт дүн шинжилгээ хийхэд өөрийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хэрэглэсэн бол хэрэглэсэн, бусдын нэр дээрх тээврийн хэрэгслийг хэрэглэсэн бол ашигласан гэж үзсэн байна. Уг зүйлд “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого”-д “гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно” гэсэн нь мөн ойлгомжгүй байна. Үүний зэрэгцээ “завдсан” гэдгийг тайлбарлах шаардлагатай юм. Мөн заалтын “гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж” гэснийг тайлбарлах, чухам ямар зорилгоор ийм заалт оруулсныг тодруулах шаардлагатай. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгсэл нь бусдын хууль ёсны өмч байвал хураах эсэх, эсхүл

үнэлгээ хийлгэж, үнийг гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гаргуулах эсэх асуудлыг хуульчлах нь зүйтэй.

- 2.29. Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дах заалтад “өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна” гэж ерөнхий нөхцөлийг заасан хэдий ч хүнд гэмт хэрэгт холбогдох юм бол хорих ялын хугацааг хоёр дахин бууруулж, заавал хорихоор зохицуулжээ. Тухайлбал, бусдын орон байранд нэвтэрсэн бол хохирол учруулсан эсэхээс үл хамаарч 2-8 жил хорих бөгөөд энэ хугацааг 1-4 жил болгон өсвөр насны хүнийг заавал хорихоор байна. Энэ нь хуулийн зарчим, олон улсын хүүхдийн эрхийн хэм хэмжээтэй зөрчилдөж байна. Энэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө Зайсанд 1 хүүхэд байсан бол одоо 41 хүүхэд байна.

Санал: ЭХЕА-ийн 8.6, 8.7-д “хүнд” гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг хамааруулахаар өөрчлөлт оруулах

- 2.30. Хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дах заалт, 8.7 дугаар зүйлийн 1 дэх заалтууд хоорондоо зөрчилдөж байна. 8.1 дүгээр зүйлийн 5 дах заалтаар шүүхээс 18 насанд хүрсэн ба 21 насанд хүрээгүй хүнд өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болохоор заасан бөгөөд 8.7 дугаар зүйлийн 1 дэх заалтаар хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж, нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно гэж заасан. Энэ нь ял өгчхөөд тэрийгээ тэнсэж, тэгээд албадлага болгох эсэх нь эргэлзээтэй байна.
- 2.31. Хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд заавал хорих ял оногдуулахгүйгээр 8.3 дугаар зүйлийг журамлаж, нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулж болох уу. Өсвөр насны хүнд ял оногдуулахдаа 8.5 дугаар зүйлийн 1 дэх заалт, 6.7 дугаар зүйлийг давхар хэрэглэж болох эсэх нь эргэлзээтэй.
- 2.32. Хуулийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх заалт, 6.7 дугаар зүйлийн 1.3 дах заалттай хамт хэрэглэх боломжтой байтал хамт хэрэглэхгүй байгаа нь хүүхдийн эрх зүйн байдлыг дордуулж байна. Хамт хэрэглэж болохгүй гэсэн заалт байхгүй байхад УДШ-ээс хамт хэрэглэж болохгүй гэсэн зөвлөмж гаргасан нь насанд хүрээгүй шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж байна.

Санал: УДШ-ийн зөвлөмжийг хүчингүй болгох

- 2.33. Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өсвөр насны хүнд анх удаа гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахаар заахдаа хөнгөн гэмт хэрэг гэж заасан нь хүнд гэмт хэрэг анх удаа үйлдсэн өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулж байна.

Санал: Үйлдсэн гэмт хэргийн шинж, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзан үзэж хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах талаар хуулийн зохицуулалт нэмэх.

- 2.34. Хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй байлгахын тулд хуулийн этгээдэд оногдуулах үндсэн ялыг зөвхөн торгох санкцтай байлгахгаас гадна Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндсэн ял болгох шаардлагатай.
- 2.35. Хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1, 11.1 дүгээр зүйлийн 2.5 дах заалтын зүйлчлэл тодорхой бус байна. Энэ 2 заалтыг хольж хэрэглэх явдал гарахаар байна.
- 2.36. Эрүүгийн хуулийн 10.2, 11.2 дугаар зүйлд байгаа “санаа сэтгэл хүчтэй цочрон давчдах” гэсэн нэр томъёог тодорхойлоогүй нь практикт хууль хэрэглэхэд хүндрэл үүсгэж байна.
- 2.37. Эрүүгийн хуулийн 10.5 дугаар зүйлд “эх нярай хүүхдээ алах” гэх заалтын тайлбарт “Нярай хүүхэд гэж төрөөд 3 хоносон хүүхдийг хэлнэ” гэснийг эхийн сэтгэл санааны хямралтай уялдуулан өөрчлөх шаардлагатай.
- 2.38. Хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалтад “зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн” гэсэн хэсэгт “эд зүйл” орхигдсон байна. Мөн тусгайлан бэлтгээгүй эд зүйл хэрэглэсэн бол хэрхэн зүйлчлэх нь тодорхойгүй.
- 2.39. 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулсан” бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасах ялыг заавал хэрэглэхээр заасан бөгөөд гудамжинд иргэн бусад хүний эрүүл мэндэд болгоомжгүйгээр хохирол учруулсан тохиолдолд ямар эрхийг хасах нь тодорхойгүй, тохиромжгүй байна.
- 2.40. 2002 оны Эрүүгийн хуулийн 138, 183 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хуулийн 11.3, 11.5-д заасан гэмт хэргээс тусад нь бие дааж хуульчлах шаардлагатай.
- 2.41. Хуулийн 11.4, 11.6 дугаар зүйлд 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хүндрүүлэх нөхцөл байдлыг иш татан зохицуулсан нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглосон зарчимд харшилж, ойлгомжгүй, тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгосон. Тухайлбал, “онц харгис хэрцгийгээр хөнгөн хохирол учруулах” гэсэн нэр томъёог тайлбарлах шаардлагатай.
- 2.42. Аль хөнгөн зүйлээр нь зүйлчлэх замаар ял завших боломжийг олгож байна. Тухайлбал, хуулийн 11.7 дугаар зүйлийн 1.1-т “байнга зодох” гээд оруулчихсан, өмнө нь ийм заалт байгаагүй. Байнга гэдэг нь 3-аас дээш удаа зодсоныг хэлнэ гээд практикаар ойлгоод байна. Одоо байнга зодсон нь тогтоогдохгүй юм чинь гэмтлийн зэрэг тогтоолгоод хөнгөн гэмтлээр оруулж, хөнгөн ял өгөөд явуулчихдаг. Нэг сая хүртэл төгрөгөөр торгоно. Энэ нь эргээд гэр бүлдээ дарамт учруулж байна. Нэг удаа зодсон нь зөрчлийн хуулиар шийтгүүлдээ байнга буюу 3-аас дээш удаа зодсон нь хөнгөн шийтгэл авч байна.
- 2.43. Хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх заалтын “байнга”, 17.1 дүгээр зүйлийн 3.1, 17.2 дугаар зүйлийн 3.1, 17.3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтуудад байгаа “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэдгийг хэрхэн ойлгох талаар тайлбар байхгүй. Шүүхээс энэ тухай зөвлөмж гаргасан хэдий ч зөвлөмжийг шүүгч бүр мөрддөггүй. Шүүх хуралдааны үеэр олсон мөнгөөрөө юу хийсэн бэ гэсэн асуултад архи уусан гэвэл амьдралын эх үүсвэр болоогүй гэж үзэх жишээтэй.
- 2.44. 12.1 дугаар зүйлийн 4 дэх заалтад “Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн...” гэж онцгойлон, бусад насныхныг ялган үлдээсэн, заавал “хохирогч нас барсан бол...” гэх үндэс нь юу вэ? Энэ бол насан туршийн “Сорви” юм.
- 2.45. Хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4, 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын тайлбар ойлгомжгүй байна. Үндсэн бүрэлдэхүүний шинжийг хангаж байж хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг хангасан байх ёстой. Хулгайлах гэмт хэргийг 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт үндсэн бүрэлдэхүүнээ хангаагүй байхад, орон байранд нэвтэрч 300 мянгаас доош төгрөгийн эд зүйл хулгайлах үйлдлийг хүнд гэмт хэргээр зүйлчилж байгаа нь эрх зүйн байдлыг дордуулж байна.

Санал: Гэмт хэргийн үндсэн шинжийг хангаж байж хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт тооцох тухай тайлбар оруулах.

- 2.46. 2017 онд хэрэгжиж эхэлсэн шинэ Эрүүгийн хууль “бэлгийн эрх чөлөөнд халдсан гэмт хэрэг”-ийн эрх зүйн зохицуулалтыг дордуулсан. Хуулийн 12.5 дугаар зүйлд “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох” гэдэг дээр... Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг 14 нас хүрсэн 16 нас хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол... гэж хуульчилсан нь бэлгийн харьцаанд орох насыг шууд 14 нас гэж заан өгчээ. Энэ нь “14 наснаас дээш насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж болох агуулгатайгаар хуульчилж өгсөн” нь хүүхдийн эрхийг ноцтойгоор зөрчсөн эрх зүйн зохицуулалт болжээ. Нөхөн үржихүйн эрхтэн нь бүрэн хөгжиж гүйцэх насыг бэлгийн харьцаанд орох нас гэж үзэн энэ талын сайн хуультай зарим оронд 14-15 насыг бэлгийн харьцаанд орох нас гэж заадаг бол улс орон бүр харилцан адилгүй, жишээ нь БНСУ-д 21 нас гэж заадаг. Харин Монгол Улсын хувьд бэлгийн харьцаанд орох насыг хуулиар тогтоож өгөөгүй. Ер нь энэ ойлголтыг 18 насаар авч үзэх нь зүйтэй. Эрүүл мэндийн байгууллага, эмч нар, шинжлэх ухааны салбарынхан монгол хүний бие махбодийн онцлогтой уялдуулан бэлгийн харьцаанд орох насыг тодорхойлох шаардлагатай юм.
- 2.47. 2017 онд хэрэгжиж эхэлсэн шинэ Эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт зөрчилтэй, уялдаа холбоогүй зүйл, заалтуудтай болсон. Тухайлбал, Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн үйлдэгдэж буй хэлбэр, төрлийн хувьд 90 хувь нь бэлгийн мөлжлөг, 10 хувь нь хөдөлмөрийн мөлжлөгийн төрлүүд эзэлж байгаа талаар олон улсын болоод дотоод тайлан мэдээнд тусгагдсан байдаг. Шинэ Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэг хоорондоо зөрчилдөж, гэмт этгээд ял завших боломж олгосон. Тухайлбал, 12.3 дугаар зүйлийн 1 дэх заалтад байгаа “... зорчих эрхийг хязгаарлахгүйгээр...” гэсэн ойлголтыг буруугаар ойлгож, хэрэглэснээр хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн мөлжлөгөөр зүйлчилж, хөнгөн ял шийтгэл оногдуулахад хүргэж байна. Үүний улмаас хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлтийн бодит тоо мэдээ гарахгүйн зэрэгцээ, хэргийн шийдвэрлэлт буурах эрсдэл бий болж байна.
- 2.48. Мал хулгайлах гэмт хэргээс хүн хулгайлах гэмт хэрэг бага ял шийтгэлтэй байна. Тухайлбал, хүндрүүлэх нөхцөлтэй мал хулгайлах 5-12 жил, харин хүндрүүлэх нөхцөлтэй хүн хулгайлах юм бол 2-8 жил байгаа нь малаас дор статустай байна.
- 2.49. Хуулийн 13.5 дугаар зүйлийн 1 дэх заалт дах мэдээллийн хэрэгслийн гэмт хэргийг захиргааны зөрчил гэж шийдэж байна. Гэтэл уг үйлдлийг зөрчил, гэмт хэрэг гэж зааглах хохирлын хэмжээ, шалгуур нь тодорхойгүй байна.
- 2.50. Хуулийн 13.8 дугаар зүйлийн “Орон байрны доторх орчин” гэдгийг тодорхойлох шаардлагатай байна. Тухайлбал, тухайн орчинд болсон үйл явдал, мэдээ, мэдээлэл зэргийг ойлгоно гэх зэргээр тайлбарлах шаардлагатай. Мөн дуу, дүрс бичлэг хийх, дамжуулах зэрэг нотлох баримтыг цагдаагийн ажилтнууд зөвшөөрөлгүй бүрдүүлж хэргийн материалд хавсаргаж байгааг шүүх нотлох баримт гэж үзэх үү?
- 2.51. Хуулийн 14.1 дүгээр зүйлийн “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн томьёоллыг “үзэн ядах” гэмт хэрэг болгон томьёолох шаардлагатай. Ялгаварлан гадуурхах нь үзэн ядах гэмт хэргийн сэдэл нь байдаг бөгөөд үзэн ядалтын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудал ЕАБХАБ, ОУ-ын Прокуроруудын холбооны гарын авлагын үзэл санааг тусгах шаардлагатай. Мөн ялгаварлан гадуурхах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр өөрчлөлт оруулах нь зүйтэй.
- 2.52. Хуулийн 14.3 дугаар зүйлийн 1, 14.4 дүгээр зүйлийн 1, 17.6 дугаар зүйлийн 1, 21.6 дугаар зүйлийн 1 дэх заалтад заасан “ноцтой хор уршиг” гэдэг ойлголтыг тайлбарлах шаардлагатай. Хуульд туссан тодорхой бус, хүч нэмэгдүүлсэн үгсийг ялгаж тайлбарлах

шаардлагатай байна.

- 2.53. Хуулийн 14.8 дугаар зүйлийг хасаж, зөрчил болгох нь зүйтэй. Учир нь 2002 оны Эрүүгийн хуульд заасан гүтгэх, доромжлох гэмт хэрэг нь зөрчил болсонтой адилаар зөвхөн сонгуулийн үеэр гүтгэх, доромжлох төрлийн гэмт хэрэг байх шаардлагагүй.
- 2.54. Хуулийн 15.1 дүгээр зүйлд заасан “эмнэлгийн мэргэжилтэн”, 23.5 дугаар зүйлийн 2-т заасан “эмнэлгийн ажилтан” гэснийг Эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн томъёолох шаардлагатай.
- 2.55. Хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Бага насны хүүхэд” гэснийг “хүүхэд” болгох нь зүйтэй.
- 2.56. Хуулийн 15.5 дугаар зүйлийн “хүчээр таслан зогсоосон үйлдэл” гэдэгт юуг хамааруулан ойлгохыг тодорхойлох шаардлагатай байна. Мөн эрх хасах ял нэмэх шаардлагатай.
- 2.57. Хуулийн 16.2 дугаар зүйлийн гипотиз хэсэгт бусад гэх үгийг нэмэх шаардлагатай. “бусад донтох” гэж томъёолсноор энэ зүйл заалтыг хэрэглэхэд ойлгомжтой болох боломжтой. Тухайлбал, бусад гэснээр цавуу, цахим тоглоомд донтох байдлыг хамаарах боломжтой.
- 2.58. Хуулийн 16.7 дугаар зүйлд “хэрцгий” гэснийг “зүй бус” гэж өөрчлөх нь зүйтэй.
- 2.59. Хуулийн 16.7 дугаар зүйлийн 2 дах заалтад “Энэ гэмт хэргийг багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн...” гэсний дараа “үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагаа хэрэгжүүлэх цагдаа, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан” гэж нэмэх шаардлагатай.
- 2.60. Хуулийн 16.10 дугаар зүйлд “хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх” гэмт хэргийн тодорхойлолтыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182-р конвенцид нийцүүлэх нь зүйтэй.
- 2.61. “Хүүхдийг хууль бусаар үрчилсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх” асуудал орхигдсон. 2002 оны хуулийн 116 дугаар зүйлээр хүүхдийг хууль бусаар үрчилсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байсан. Тухайлбал, иргэн А өөрийн бичиг баримтаар жирэмсэн эх Б-г төрөх тасагт хэвтүүлж, өөрийн бичиг баримтаар Б-г А гэж итгүүлсэн. Хүүхэд төрсний дараа хүүхдийг төрүүлсэн эх Б-ээр биш, А-аар овоглуулж, А нь уг хүүхдийг өөрийн хүүхэд болгосон. Үрчлэлт хууль ёсоор хийгдээгүй боловч хүүхэд төрүүлсэн эх биш өөр хүний асрамжид хууль бусаар шилжсэн. Энэ тохиолдолд хүүхэд худалдсан гэмт хэргийн шинж байхгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх нь тодорхойгүй байна.
- 2.62. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэргийн 1 дэх заалт материаллаг хохирол шаардаж, 300000 төгрөгийн босго тавьсан боловч, 2, 3 дах заалтад хүндрүүлэх нөхцөлийг заахдаа 1 дэх заалтад заасан материаллаг хохирлыг шаардахгүй болсон нь ерөнхий ангийн шударга ёсны зарчимтай зөрчилдөж байна. Орон сууц, байранд нэвтэрсэн л бол 2-8 жилийн хорих ял авах болсон. Ялангуяа өсвөр насны хүүхдүүд ийм хэргээр хорих ял шийтгэгдэх нь түгээмэл болсон. Гэтэл хүний халаас ухаж, 300000 хүртэл төгрөгийн хохирлыг хэдэн удаа ч учруулсан Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдээд явахаар байна. Хулгайлах гэмт хэрэгт 300 нэгж гэсэн босго тавьсан нь тухайн гэмт хэрэгтэй тэмцэх хүн хүчтэй холбоотой гэж ойлгож байна. Тиймээс босго тавилгүй, гэмт хэрэг гэж тооцон хүн хүчээ нэмэгдүүлж ажиллах шаардлагатай. Зөрчлийн тухай хуулийн хулгайлах зөрчлийг хасаж, хулгайлах гэмт үйлдлийг зөвхөн Эрүүгийн хуулиар зохицуулдаг болох нь зүйтэй. Эсхүл 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг материаллаг бүрэлдэхүүнтэй болгох шаардлагатай.
- 2.63. Хуулийн 17.1-р зүйлийн 3.1 дэх хэсгээс байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг хасах шаардлагатай. Учир нь энэ шинж тоон талаасаа 3 болон түүнээс дээш удаа хулгайлах гэмт хэрэг үйлдсэн байх агуулгатай учраас эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3-т заасан шударга ёсны зарчимтай зөрчилдөж байна.
- 2.64. Хуулийн 17.1, 17.12 дугаар зүйлүүд зөрчилдөж байна. Мал хулгайлах гэмт хэрэгт хохирол зааж өгөөгүй нь эрх зүйн байдлыг дордуулсан. Тухайлбал 17.1 дүгээр зүйлийн 1 дэх

заалтаар хүнээс 200,000 төгрөг хулгайлахад гэмт хэрэгт тооцохгүй атал 20,000 төгрөгийн хурга хулгайлахад мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэж ял оногдуулж байна.

- 2.65. Хулгайлах гэмт хэрэг үйлдэн шалгагдаж байгаа этгээдүүд тэр дундаа бүлэг, зохион байгуулалттай, олон үйлдэлтэй гэмт этгээдүүдийн хэрэгт шүүх ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж, нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хэд хэдэн гэмт хэрэгт хэд хэдэн төрлийн ял оногдуулсан бол доор дурдсанаар хөнгөн ялыг хүндэд нь нэмж нэгтгэх, эсхүл тус тусад нь эдлүүлэхээр шийдвэрлэж болно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэхгүйгээр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн тусгай ангид заасан нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр хангасан байвал үргэлжилсэн нэг гэмт хэрэг үйлдсэнд тооцно”, ЭХХШТХ-ийн 29.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол хэргийг нэгтгэж мөрдөн байцаалт явуулж болно” гэсэн заалтыг үндэслэн хэрэг нэг бүрийг тус тусад нь шийдвэрлэхгүй байгаа нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зарчмыг алдагдуулж, өмнөх хуультай адил “Яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй” гэх үндэслэлээр хэрэг бүрийг нэгтгэн шүүхээр хэлэлцэх зарчмыг баримталж байгаа нь мөрдөн шалгах ажиллагааны хугацаа сунгах, шалгалтын ажиллагаа удаашрах, гэмт хэрэгтнүүд дахин гэмт хэрэг үйлдэх, оргон зайлах сөрөг үр дагаврыг бий болгож байна.
- 2.66. 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 2002 оны Эрүүгийн хуулийн Булаах гэмт хэргийг хуульчилж, 2 дахь хэсэгт мөн хуулийн Дээрэмдэх гэмт хэргийг хуульчилсан байна. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэж болохгүй гэх зарчмын агуулгыг зөрчих нөхцөл байдлыг бүрдүүлж байна. 2 өөр төрлийн гэмт хэргийг нэг зүйл болгосон учир 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг шинэ зүйл, заалт болгож, “булаах” гэмт хэрэг нэмэх шаардлагатай байна.
- 2.67. Хуулийн 17.2 дугаар зүйлийн дээрэмдэх зүйлээр зөвхөн цохиж хөхрүүлсэн үед хүнд ялаар шийтгэж байна. Гэвч дээрэм гэдэг нь маш хүнд нөхцөл байдалд оруулж эд зүйлийг нь булаан авахыг хэлдэг. Цагдаагийн байгууллагын шинжээч нар шүүхийн гэмтлийн зэрэг тогтоох заавраа хэрэглэдэггүй. Тиймээс олон хүн хэлмэгдэж байна. Хуулийн шинжийг тодорхойлохдоо анхааралтай хандах ёстой. Дээрмийн заасан шинжүүдийг эргэж харах, ялын бодлогын хувьд харгалзан үзэх шаардлагатай.
- 2.68. Мал хулгайлах гэмт хэргийн 17.12 дугаар зүйлийн 3.1 дэх заалтаар амьдралын эх үүсвэр болгосон гэснийг шүүхийн зөвлөмжид ямар ч орлогогүй тохиолдолд гэж үзээд, харин малтай бол энэ заалтаар хүндрүүлэхгүй байгаа нь шударга ёсны зарчимд үл нийцэж байна.
- 2.69. Хуулийн 17.12 дугаар зүйлээс зөрчих эрхийг хязгаарлах ялыг хасах шаардлагатай.
- 2.70. Мал хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулиас хасаж, хулгайлах гэмт хэргээр зохицуулдаг болох нь зүйтэй. Малын хулгай нь халдлагын зүйл нь мал байдгаараа хулгайн гэмт хэргээс ялгагддаг. Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь халдлагын зүйлээр хоёр өөр төрлийн хулгайлах гэмт хэрэг болгон ялгаснаас болж зөрчигдөж байна. Мөн хууль тогтоогч үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохдоо хүний эрх зүйн байдлыг дордуулж болохгүй. Гэтэл олон тооны мал гэсэн тайлбараас болж холбогдох этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан гэж үзэж байна. Иймд энэ гэмт хэргийг Эрүүгийн хуулиас хасах саналтай байна.
- 2.71. Хуулийн 18.5 дугаар зүйлийн 3 дахь заалтад “түүх” гэсэн үгийг нэмэх нь зүйтэй. Учир нь түүхийн дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд гэмт хэрэгт тооцогдохооргүй байна.
- 2.72. Хуулийн 18.10 дугаар зүйлийн 1.2, 11.6 дугаар зүйлийн 1.2, 21.14 дүгээр зүйлийн 1.2, 22.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтад заасан гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ өмнөх хэсэгтэйгээ яг адил байгааг эргэж харах шаардлагатай.

- 2.73. Хуулийн 20.7 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэх үйлдлийг тусгаагүй байх тул “байнга хэрэглэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцох шаардлагатай
- 2.74. Хуулийн 20.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хүндэвтэр” гэснийг “хөнгөн” гэж өөрчлөх шаардлагатай.
- 2.75. Хуулийн 20.16 дугаар зүйл маргаантай байна. Хуучин хуулийн танхай гэж үзэж байхад зарим газар эсрэгээр нь үздэг. Энэ заалтыг нэн яаралтай шийдвэрлэж, хуучны 179 эсхүл 181-ийн аль нь болохыг тодруулах шаардлагатай байна.
- 2.76. Хуулийн 21.1 дүгээр зүйлд “хэрэг шалган шийдвэрлэх” гэдэгт эрүү, иргэн, захиргааны хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг хамруулах эсэхийг тодорхой болгох шаардлагатай.
- 2.77. Хуулийн 21.2 дугаар зүйлийн 1 дэх заалтад “гэрч, хохирогчийн эрх хасна” гэх ойлголт байх боломжгүй. Иймд “...гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасах...” ялыг хүчингүй болгож томъёолох, мөн “эрүү, иргэн, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед” гэж өөрчлөх шаардлагатай.
- 2.78. Хуулийн 21.7 дугаар зүйлд үйлдэл нэг бүрийг тус бүрд нь заасан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж байгаа эсэхийг ялгамжтай хуульчлах шаардлагатай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийх гэдгийг Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалттай уялдуулах нь зүйтэй. Шүүхийн шийдвэрийг огт биелүүлэхгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх, яллагдагчаар татсаны дараа шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх нь тодорхойгүй байна.
- 2.79. Шинэ хуулийн 21.11 дүгээр зүйлийн “Оргон зайлах” гэдэг дээр “Баривчлагдсан, цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан бол...” гэдэг дээр дутуу зүйлс байна. Тухайлбал, байцаагдаж байгаа, батлан даалтад гараад гадуур шалгагдаж байгаа, мөрдөн байцаалтын явцад мэдүүлэг өгч байгаа хүмүүс, сэжигтнийг үүн дээр нэмж оруулах нь зүйтэй.
- 2.80. Хуулийн 21.11 дүгээр зүйлд “сэжигтэн, яллагдагч мөрдөн байцаалтаас оргон зайлах” гэж нэмж оруулах шаардлагатай.
- 2.81. Учруулсан хохирлын хэмжээг харгалзан үзэж хээл хахууль авсан, албаны эрх мэдлээ урвуулан ашигласан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн этгээдүүдэд оногдуулах ялыг чангатгахгүй бол хөнгөн хэргээр зүйлчлэгдэж ял завших, дахин төрийн албанд ажиллах чиг хандлага ажиглагдаж байна. Хөнгөн хэргээр хөөн хэлэлцэх хугацаа богино, хэрэг хянан шийдвэрлэх үйл явц сунжирдаг байдлаас үүдэн хууль бусаар гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан хөрөнгө орлогыг хураах боломжгүй нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал, улсад тэрбум төгрөгийн хохирол учруулсан этгээд дээд тал нь 27 сая төгрөгөөр торгуулах эсхүл дээд тал нь 5 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хорих ялаар шийтгүүлэх заалттай байна.
- 2.82. Хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1, 27.7 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөний улмаас бодит хор уршиг учрахыг шаардахгүй буюу хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилсан боловч ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх заалтад “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэх заалтын дагуу эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болж, гэмт этгээд ял завших нөхцөл бүрдсэн. Мөн ЭХХШТХ-ийн 1.15-р зүйлийн 2 дох хэсэгт “эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч,

ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсэн зарчмаар ял завших боломжийг олгож байна. Хэдийгээр албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хуульчилсан нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нийцсэн ч Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4, ЭХХШтХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дах заалттай зөрчилдөж, улмаар эрх зүйн маргаан дагуулж, ял завших, шударга ёсны үнэлэмжийг бууруулах хандлагатай байна.

- 2.83. Хуулийн 22.8 дугаар зүйлийн 1.6-д хохирлын хэмжээг тодорхой тусгаж өгөх шаардлагатай.
- 2.84. Хуулийн 22.10 дугаар зүйлд “үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол” гэснийг “нотолж чадаагүй бол” гэж өөрчлөх шаардлагатай.
- 2.85. 2002 оны Эрүүгийн хуулийн 264-р зүйлд төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэх зүйл ангийг хуульчилсан байсан бөгөөд төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс иргэн, ААН байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байсныг хассан.
- 2.86. Хуулийн 23.7 дугаар зүйлд заасан нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэдгийг хэрхэн ойлгож, ямар тохиолдолд, яаж хэрэглэх нь тодорхойгүй, ерөнхий байна. Цагдааг эсэргүүцвэл хууль сахиулагчийг эсэргүүцсэн гэж хэрэг үүсгэдэг атал сумын засаг даргын шийдвэрийг цагдаа эсэргүүцэхэд 23.7 дугаар зүйлд зааснаар хэрэг үүсгэдэггүй.
- 2.87. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш байгаль орчинтой холбоотой гэмт хэрэг, зөрчилд цагдаагийн байгууллага хэрхэн ажиллаж байгаа талаар Хөвсгөл далайн эзэд ТББ Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн алтны шороон орд, Туул тосгон хоёрт хамтран ажилладаг ТББ-тай хамт мониторинг хийсэн. Энэ түрүүнд энэ нь байгаль орчинтой холбоотой зөрчил юм байна, тэр нь гэмт хэрэг юм байна гэж ялгаад ийм төрлийн гэмт хэрэг, зөрчилд цагдаагийн байгууллага хэрэг бүртгэл хэр хийж, хэрхэн хариуцлага хүлээлгэж байгааг судлах зорилгоор мониторинг хийсэн. Заамар сумын Хайлааст баг дээр л гэхэд 45 хүнтэй цагдаагийн хэлтэс ажиллаж байгаа ч “Энэ бол цагдаагийн байгууллагын хийх ажил биш, Байгаль орчны яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ажил, орон нутгийн захиргаанд ханд” гэдэг. Тэдгээр байгууллагад нь хандахаар Туул голын сав газрын захиргаа “Энэ бол хууль зөрчсөн хэрэг байна” гэсэн дүгнэлт гаргасан. МХЕГ болохоор бүр хойно, алтны уурхайн үйл ажиллагаа аль хэдийнээ зогссон үед “Энэ бол хууль зөрчсөн үйлдэл тул үйл ажиллагааг нь зогсоолоо” гэх жишээтэй. Мөн хайрга дайрганы үйлдвэрлэл явуулж байгаа компанийн гаргасан 13 төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлээд, мэдээлээд байхад хүртэл цагдаагийн хоёр хэсгийн аль аль нь бүртгэж аваагүй. Энэ талаар прокурорт гомдол гаргахаар прокурор цагдаагийн байгууллагад “Энэ хэргийг бүртгэж ав” гэсэн ч хэсгийн төлөөлөгч нь зөвхөн байгаль орчинтой холбоотой хэрэг, зөрчлийг л ялган авч, 24 цагийн турш ажиллан хүмүүсийн тав тухыг алдагдуулж байгаа компаниудын үйл ажиллагааг “Угаасаа өдрийн цагаар хүнд даацын машинаар тээвэр хийж ажиллахыг хориглодог журамтай юм байна. Тэр л журмынхаа дагуу ажиллаж байна” гээд хэрэгсдэггүй. Гэтэл амьдрал дээр хууль бус алт олборлолт их байгаа, гол усны, жишээ нь, Туул голын голдрилыг хүртэл өөрчлөөд байгаа. Статистикаас харахад Монгол Улсын хувьд ч, саяын сонгож авсан хоёр газрын хувьд ч байгаль орчинтой холбоотой гэмт хэрэг олон гардаг атлаа хариуцлага хүлээхгүй байна. Гэмт хэргийн шинжтэй олон үйлдлийг зөрчилд тооцсон нь хариуцлагаас шууд зугтаалгаж байгаа хэрэг. Тиймээс гэмт хэргийн зүйлчлэлийг илүү нарийн зааж өгөх, зохих ажиллагаа хийх хэрэгтэй байна. Эрүүгийн хуулийн 24.2.1-т “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал хайсан, олборлосон, боловсруулсан, ашигласан... бол 5400 нэгжээс 27 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн нь байгаль орчинд үүсгээд буй хохиролтой харьцуулахад маш хөнгөн шийтгэл болсон. Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа хавтгай байгаа ч хариуцлага байхгүй.
- 2.88. Хуулийн 24.2 дугаар зүйлийн 2 дах заалтад “Олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас байгаль орчинд ноцтой хохирол учруулбал 10 мянгаас 40 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн ч хэрэг дээрээ бараг шийтгэдэггүй. Ноцтой хохирол гэсэн тодорхойгүй нөхцөл тавьсан.

- 2.89. Хуулийн 24.2 дугаар зүйлийн 3 дах заалтад “хуулийн этгээдийн эрхийг хасна” гэж заасан ч энэ шийтгэлийг ногдуулж байгаа хүн алга, тиймээс энэ заалт хэрэгжихгүй байна.
- 2.90. Хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дах заалтад байгаа хоёр таслалын нэгийг хасч, “нэн ховор” гэж нэмэх шаардлагатай.
- 2.91. Хуульд тусгай хамгаалалтгүй газар нутагт амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнаж, үлэмж хэмжээний хохирол учруулсан бол гэсэн нэмэлт заалт тусгах шаардлагатай байна. Тусгай хамгаалалттай газарт 1 тарвага агнахад эрүүгийн гэмт хэрэг болж байгаа бол тусгай хамгаалалтгүй газар 100 тарвага агнахад зөрчилд тооцогдож байна.
- 2.92. Гол усны голдрилыг өөрчилсөн бол зөрчил биш, гэмт хэрэгт тооцох ёстой.
- 2.93. Хуулийн 24.9 дүгээр зүйлийн 1 дэх заалтад байгаль орчин, ус, агаар, газар хордуулсан тухай заалтууд байна. Усны бохирдуулалттай холбоотой заалт дээр зөвхөн хордуулсан л бол эрүүгийн хэрэг болж 8-15 жил хорихоор заасан. Тэгвэл бохирдуулсан тохиолдолд яах вэ? Зөрчил болж бохирдлын төлбөр л авч байгаа. Ямар тохиолдолд хордуулсан, ямарт нь бохирдуулсан гэж үзэхийг ялгах шаардлагатай. Тухайлбал, химийн бодистой усаа гол руу хийж байгаа нь ус хордуулж байгаа хэрэг юм.
- 2.94. Эрүүгийн хуулийн 28.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хор уршиг”-ийг гэмт хэрэгт тооцсон байгаа нь ерөнхий ангийн зохицуулалттай уялдаагүй байна.

Хуульчид

1. П.Адьяасүрэн
2. Ц. Алдархишиг
3. С.Алминцэцэг
4. Ц.Алтангадас
5. Т.Алтантуяа
6. Н.Анхбаяр
7. Ч.Анхбаяр
8. Н.Арвинтариа
9. А.Ариунзаяа
10. Н.Баасанбат
11. Ц.Баасандэлгэр
12. А.Баатар
13. Д.Бадам
14. С.Байгалмаа
15. А.Бакыт
16. Д.Батгэрэл
17. А.Батгэрэл
18. Б.Батзориг
19. Г.Батнасан
20. Б.Бат-Орших
21. Д.Батсүх
22. П.Баттулга
23. Ж.Бат-Эрдэнэ
24. М.Баярсайхан
25. Д.Баярсүрэн
26. Б.Баярхүү
27. Т.Баясгалан
28. Ч.Болдбаатар
29. Д.Болдсайхан
30. Г.Болормаа
31. Д.Бурмаа
32. Г.Бямбадорж
33. Б.Галсанжамц
34. Б.Ганбаатар
35. Т.Ганбат
36. Б.Ганболд
37. В.Ганболд
38. А.Ганзориг
39. М.Гансүвд
40. С.Гансэлэм
41. Б.Гантулга
42. Б.Гэрэлмаа
43. Ц.Дайрийжав
44. С.Дангаасүрэн
45. Б.Дашдондов
46. Д.Дашцэрмаа
47. Г.Должинсүрэн
48. Б.Дуламсүрэн
49. Ш.Ербол
50. Б.Жавхланбаяр
51. Ч.Жадамба
52. У.Жамбацэрэн
53. Б.Жаргал
54. Ч.Жаргалбаатар
55. И.Золзаяа
56. М.Лхагвасүрэн
57. Б.Мангилик
58. Б.Манлайбаатар
59. Н.Манлайбаатар
60. Т.Мөнхбадрах
61. Т.Мөнхдалай
62. Т.Мөнх-Оргил
63. Ц.Мөнхчимэг
64. Ц.Мөнх-Эрдэнэ
65. Г.Наранбаатар
66. Т.Наранбат
67. Х.Наранзул
68. П.Нарантуяа
69. С.Номынбаясгалан
70. Э.Нэмэхжаргал
71. Э.Нямбилэгт
72. Х.Одбаяр
73. Н.Онон
74. Б.Отгон
75. Ч.Отгонсүрэн
76. В.Отгончимэг
77. Ц.Оч
78. М.Очирбат
79. С.Оюун
80. Д.Оюунбат
81. П.Оюунтунгалаг
82. Б.Оюунцэцэг
83. Г.Оюунцэцэг
84. П.Өлзийбаяр
85. М.Өлзийцэцэг
86. С.Өмирбек
87. У.Содбаяр
88. Б.Соёл-Эрдэнэ
89. Д.Сүнжид
90. Б.Сүрмандах
91. Ж.Тамир
92. М.Төрмөнх
93. Я.Туул
94. Ч.Түвшинжаргал
95. Т.Урангэрэл
96. Б.Уранцэцэг
97. Б.Уранчимэг
98. Ц.Уртнасан
99. Г.Халиунаа
100. Б.Хандмаа
101. Л.Хаш
102. В.Хосбаяр
103. З.Хүрэлбагана
104. Г.Цацрал
105. Б.Цогтбаатар
106. Д.Цэндсүрэн
107. С.Цэрэндорж
108. С.Цэцэгмаа
109. С.Цэцэгсүрэн
110. Х.Чекара
111. И.Чимэдбадам
112. М.Чинбат
113. Д.Чинзориг
114. М.Чинзориг
115. О.Чулуунцэцэг
116. Б.Энхбат
117. С.Энхбат
118. Ц.Энхбаяр
119. Д.Энхболд
120. Н.Энхжаргал
121. С.Энхзаяа
122. С.Энхмаа
123. Ж.Энх-Од
124. Л.Энхсайхан
125. З.Энхтайван
126. Ж.Энхтуяа
127. Н.Энхтуяа
128. Х.Эрдэм-Ундрах
129. Г.Эрдэнэбат
130. Б.Эрдэнэ-Очир
131. М.Эрдэнэсайхан
132. Э.Эрдэнэсувд
133. Л.Эрхзаяа

Төрийн бус байгууллагын ажилтнууд

134. А.Балдангомбо
135. Б.Баттогтох
136. Б.Баярмаа
137. Б.Баярмаа
138. Г.Ганбаясгах
139. Б.Жавзанхүү
140. Д.Мягмардорж
141. Б.Онон
142. Ч.Сэмжидмаа
143. Т.Цогзолмаа
144. П.Цэвээн
145. С.Цэндбаатар

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

Хамтрагч байгууллага:



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их
эзэн Чингис хааны нэрэмжит талбай-7, Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн 4 давхар, 403 тоот
Утас: 70116007, 70116065
И-мэйл: info@mglbar.mn